

МОНГОЛ ЦЭРГИЙН ЗЭВСЭГЛЭЛ (1911-1921)

Б.Батсүрэн

Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэн

Өгүүллийн товч утга: XX зууны эхээр тусгаар тогтнол сэргээн мандуулсан Монгол Улсаас, олсон эрх чөлөө, улсын тусгаар тогтнолыг батлан хамгаалахын тулд үндэсний цэргийг байгуулж, бэхжүүлэх явдал нь сэргэн мандсан төрийн нэн чухал зорилт болсон бөгөөд эл зорилтыг хэрэгжүүлэх нэг арга хэмжээ нь гадаад улс гүрэн, хувь пүүс, хүмүүсээс зэр зэвсгийг аль болох үлэмж хэмжээгээр худалдан авч шинээр үүсгэн байгуулж буй европ маягийн өөрийн цэрэг армийг зэвсэглэх асуудал байсныг өгүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Монгол Улс, Хаант Орос улс, винтов, бердан буу, пулемет, их буу, сэлэм, сум галт хэрэгсэл, зэр зэвсэг

Орчин цагийн буу, артиллер, пулемётоор цэргээ зэвсэглэх нь 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан Монгол Улсын өмнө тулгамдсан чухал зорилт байлаа.

XIX-XX зууны эхэн үеийн шинжлэх ухааны ололтод тулгуурласан техник хэрэгсэл, Монголд далайцтай нэвтэрч ашиглагдаагүй байсан нь Манжийн төрийн бодлогын үр дагавар юм. Тиймээс зэвсэглэлийн утгаар XX зууны эхэн үеийн Монгол нь XVII-XVIII зууны Европын төвшинд оршиж байв.

Эл хоцрогдолыг арилгах дотоодын боломжгүй тул гадны зэвсгийг, гэхдээ сонгох боломж бараг тэглэсэн нөхцөлд, нэг, хоёр улсаас зээлэх, худалдан авахаас өөр арга монголчуудын хувьд байсангүй. Гадаадад айлчлах Монголын төлөөлөгчид, Монголд ирэх гадаадыхантай уулзаж байсан ноёд түшмэд, чинээлэг хийгээд үндэсний үзэлтэй хэн бүхэн зэвсэг худалдан авахыг хичээж байсан нь түүх сударт тэмдэглэгдэн үлдсэн байна. Ийм байдлаар олж авсан зэвсэг нь, сум галт хэрэгсэл зэрэгтэй холбогдох цөөнгүй асуудлыг улам төвөгтэй болгодог тул нэмэр болохоос нэрмээс болж байсан бололтой.

Иймээс Хаант Орос улсаас зэр зэвсэг худалдан авах нь зөв гарц хэмээн монголчууд үзсэн бол, Оросын эрх баригчид өөрийн улсын эрх ашиг, сонирхлыг урьтал болгон, монголчуудын хүсэлтийг биелүүлэх эс биелүүлэхээ шийдэж байв. Тухайлбал, Орос Улсад 1911.08.15-нд ирсэн Монголын төлөөлөгчид цэргийн тусламж хүссэнд, Оросын эрх баригчдаас хэрэв “манай (Бээжин дэх-Б.Б) шаардлага амжилтгүй болоод, Халхад зэвсэгт бослого гарах нь зайлшгүй болох ахул, монголчуудад зэвсэг тавьж олгох явдлыг бүрэн бололцоотой хэрэг”¹ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл 1907.07.30-ний хэлэлцээрээр* Япон нь Солонгос, өмнөд Манжуур, Орос нь Монгол, умард Манжуурт нөлөөгөө тогтоосон² ба Монголын улс төрийн байдал Оросын эрх ашигт нийцэхийн дээр өрсөлдөгч япончуудын эрх ашгийг хөндөөгүй учраас л цэрэг зэвсгийн тусламжийг 1911-1912 оны заагаар Монголд олгосон байдаг. Монголчууд Өмнөд Монголын төлөө ДИУ-ын цэрэгтэй дайтаж эхэлсэн үед албан ёсоор хэдэн удаа зэвсэг олгохыг хүсчээ. Гэтэл Япон улс Манж Чин гүрэн мөхөж монгол, түвэд, хятадууд бие даасан улс байгуулсантай уялдан, нөлөөний хүрээгээ тодорхой болгон хэрэгжүүлэх саналыг Орос тавьсны дагуу тэдгээр улс 1912 оны 7 дугаар сарын 8-нд гурав дахь удаагаа тохиролцсон юм. Дашрамд өгүүлэхэд энэ удаагийн тохиролцоогоор оросууд Синьцзяныг албан

¹ Пунцагноров Ц. Монголын автономит үеийн түүх. УБ., 1955. т. 34.

* Оросын Гадаад яамны сайд А.П.Извольский болон Орос дахь Японы элчин сайд И.Мотоно нарын Санкт-Петербург хотод гарын үсэг зурсан хэлэлцээр.

² БНМАУ-ын түүх. Дэд боть (1604-1917). УБ., 1968. т. 374.

ёсоор өөрийн нөлөөний хүрээнд хамруулах гэснийг Японы тал няцаажээ³. Тус конвенцийн ёсоор Бээжингийн уртраг дагуу Өвөрмонголыг хоёр хэсэгт хувааж, зүүн хэсгийг Япон, баруун хэсгийг Оросын нөлөөний хүрээ гэж тогтоожээ⁴. Чухамдаа энэ гэрээг баримтлан “үхэр бууны зэрэг хүчтэй зэвсэг бүхүй цэргийг зүүн зүгт” явуулж чадахгүй. Харин Хөх хотоос баруун зүгт болбоос манай засгийн газраас буу цэргийг илэрхий тусламу”⁵ гэж, дээр өгүүлсэн Монголын хүсэлтэд Оросын эрх баригчид хариу болгожээ. Жижиг Монголоос болж Японтой сөргөлдөх нь Орост ашиггүй тул монголд зэвсэг худалдаалах асуудлыг хойшлуулсаар байжээ.

Оросын ийм байр суурь Монголын эрх баригчдыг бусад улс орноос боломжийн үнээр зэвсэг худалдан авах арга эрэлхийлэхэд хүргэсэн бөгөөд Оросын зэвсгээс чанар үл дутах зэвсэглэл худалдан авах боломжийг судлах давхар даалгаварыг монголчууд өөрийн элч төлөөлөгчиддөө өгч гадаадад илгээж байсан бололтой⁶. Монголын эл алхам мэдээж Хаант Оросын ашиг сонирхолтой нийцэхгүй учир, «Монгол цэргийг зэвсэг хэрэгсэлээр хангах тухай», Орос-Монголын гэрээний эхийг консул Миллерээр дамжуулан 1914 оны IX сарын 3-нд монголд хүлээлгэн өгч шахаж шаардах болов⁷. Улмаар 1914 оны IX сарын 30-нд энэхүү дөрвөн зүйлт гэрээг баталсан бөгөөд «Буу сум худалдан авах гэрээ бичиг»-т, «Монголын Засгийн газраас гадаад аль ч улс хийгээд гадаад ба Оросын хоршоо аль ч улсын харъяат нараас буу зэвсэг үл захиомой»⁸ гэсэн заалтыг зүйлчлэн оруулсан нь дээр өгүүлсэн гаднаас зэвсэг авах Монголын оролдлогод Оросын барьсан хариу байв.

Монголчууд цэргээ зэвсэглэхэд тулгарч байсан бэрхшээлээс товч дурдахад ийм байна.

Их Хүрээнд 1911 оны VII сарын 16-нд эрх баригч ноёдын хийсэн нууц зөвлөлгөөнөөс шийдвэр гаргасны дагуу Монголын төлөөлөгчид Орос Улсад зорчих тухайгаа Их Хүрээний Оросын консулд 1911 оны VII сарын 28-нд мэдэгдэн улмаар 1911 оны VII сарын 29-нээс уван цуван Хүрээнээс гарч одсон юм. Санкт-Петербург хотноо 1911 оны VIII сарын 15-нд гурван долоо хоногийн айлчлалаар хүрэлцэн очиж⁹ улс гэрээ сэргээх хорин нэгэн зүйлийн шалтгаан тоочсон бичгийг оросын эрх баригчдад гардуулжээ. Эл бичгийн §13-т “бэлтгэсэн цэрэг үгүй боловч үлэмжхэн хурц зэвсэг олбоос муу хятад цэрэг энэ амин бүхүй хэдэн зуугаас илүүгүй бол ер айх явдалгүй. Гагцхүү далдуур нууц бэлтгэсэн цэрэг байх ба дотоод газраас их цэрэг гаргаж ирэх болбоос хүчин тэнцэхгүй болох тул одоо даруй тэнгэрийн цэрэг

³ Советская историческая энциклопедия. Том. XII. М., 1969. с. 972.

⁴ Орос, Японы нөлөөний хүрээний зааг шугам нь Манжуурын Сунгар-Ула мөрөн, Монголын Тоорын голоор Их Хинганы нуруунд хүрээд тус нурууны оройгоор Бээжинг чиглэн явсаар Өрөөсөн Чулуун хаалга боомтод хүрдэг [Дальний Восток. 1913. №51. с. 7] ба энэ шугмаас дорно этгээдэд орших монголчуудын газар нутаг Японы нөлөөний бүсэд багтах болжээ.

⁵ Батсайхан О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916). УБ., 2002. т. 101-102.

⁶ Өөрөөр хэлбэл Хинган нурууны зүүн этгээдэд, тухайлбал Жирим, Зуу-Уд, Зостын чуулганд гэсэн үг.

⁷ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 183-184.

⁸ Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 40.

⁹ Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны гэрээ (өдөр тутмын тэмдэглэл). УБ., 1999. т. 577; Хишигт Н. Монгол улсаас хаант Оростой цэргийн салбарт байгуулсан гэрээ хэлэлцээрүүд (1912-1917) // SH. Tom. 32. УБ., 2002. т. 13.

⁸ Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. УБ., 1994. т. 72.

⁹ Батсайхан О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916). УБ., 2002. т. 35.

(орос цэрэг-Б.Б) илгээж туслан хамгаалахыг¹⁰ хүссэн нь оросоос цэрэг, зэвсгийн тусламж авахыг зорьсон хэрэг болсон ажгуу.

Хаант Орос улсын Сайд нарын Зөвлөлийн даргын удирдлагаар сан, худалдаа, аж үйлдвэр, гадаад явдлын ба цэрэг, тэнгисийн яамдын сайд болон бусад өндөр албан тушаалтан оролцсон 1911 сарын VIII сарын 17-ны Алс Дорнодын хэргээрх Онцгой зөвлөлгөөнөөр “«...Монголын асуудалд идэвхтэй оролцохгүйгээр... тэр хоёрын (Монгол, Чин улсын-Л.Ж) хооронд зуучлан Монголоос Чин улстай тогтоосон сюзерений холбоог таслалгүйгээр үндэсний байдлаа хамгаалах гэсэн монголчуудын эрмэлзлэлийг дипломат замаар дэмжих»”¹¹ шийдвэрийг баталжээ. Энэ шийдвэрээр ойрын таван жилд баримтлах бодлогыг, цэрэг зэвсгийн тусламж зэрэг асуудлыг хамруулан боловсруулжээ. Монголчуудад зэвсэг олгохыг зарчмын хувьд бүрэн боломжтой гэсэн эрх баригчдынхаа шийдвэрээр Цэргийн яамны сайд В.А.Сухомлинов цаашид монголчуудад шилжүүлэн олгох зорилгоор Эрхүүгийн цэргийн тойргийн штабт 15 мянган винтов, 7.5 сая сум тус тус олгохыг 1911 сарын X сарын 17-нд тушаажээ¹².

Оросын эрх баригчдын шийдвэрийг сонссон Монголын төлөөлөгчид 1911 оны VIII сарын 30-нд Москвад ирсэн хойноо хагас сар орчим мөнөөх зэвсэг олгох зөвшөөрөл зэргийг хүлээсний эцэст Эрхүүд ирсэн байна. Эрхүү хотоос 1911 оны X сарын 4-нд гарсан төлөөлөгчдийн нэг да лам “Цэрэнчимэд зүсээ хувирган явсаар 1911 оны X сарын 25-нд Их Хүрээнд”¹³ иржээ. Улмаар 1911 оны XI сарын 7-нд Цэрэнчимэд Котвичэд захидал илгээхдээ Манжийн амбан Саньдо Монголын ноёд, түшмэдийг айлгасан тул зарим “ухвар мөчид ноёд бачимдаж, тэр газраа байх буу одоогоор бидэнд тусгүй, бид хамгаалах цэрэг гуйснаас өөр буу гуйсангүй гэж хэлсэн” хэмээн мэдэгджээ. Харин Цэрэнчимэд учрыг “ухуулан хэлсэнд ноёд сая ухаж мэдээд их л баярлан урам орж консулд очиж урьд учрыг цагаатган гаргаж зэвсэг олгохыг гуйсанд консул ёсоор болгож цахилгаан мэдээгээр”¹⁴ уламжилсан аж.

Үүний зэрэгцээ Монголд үүссэн байдалд зэвсэг их хэрэгтэй учир, Эрхүүд үлдсэн Хайсанд, 1911 оны XI сарын 5-нд “Хаант Оросоос олгох зэвсгийг түргэн ирүүлэх талаар хөөцөлдөхийг”¹⁵ анхааруулсан захидалыг Цэрэнчимэд илгээжээ. Гэвч Оросын тал Өргөө (Их Хүрээ-Б.Б) дэх нөлөө бүхий этгээдээс зэвсэг зайлшгүй шаардлагатай гэсэн хүсэлтийг дахин тавихаас нааш асуудал шийдвэрлэгдэхгүй¹⁶ гэж мэдэгдсэнийг, Котвич Хүрээний нэгэн эрх баригчид захидал бичихдээ

¹⁰ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ, 1982. т. 166.

¹¹ Жамсран Л. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ, 1997. т. 18; Лузянин С.Г. Россия-Монголия-Китай в первой половине XX века. Политические взаимоотношения в 1911-1946 гг. М., 2003. с. 54.

Сухомлинов Владимир Александрович. (1848.08.04-1926.02.02) генерал адъютант ба морин цэргийн генерал цолтой. 1909.03-1915.06 сард Хаант Орос улсын ЦЯ-ны сайд байсан.

Энэ Юлианы тоолол бололтой. Григорианы тооллоор бол 1911.10.30 болно. Тэгээд ч Оросын Эрхүүгийн цэргийн тойргийн командчлагч их бууны генерал В.Н.Никитинээс ЦЯ-ны сайд В.А.Сухомлиновт 1912.02.17-нд илтгэсэн айлтгалаар бол монголчуудад зэвсэг өгөхийг заасан тушаал 1911.11.04-нд цахилгаан мэдээгээр ирсэн байна [РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7904. л. 194 об. Эх Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Окунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц, Дмитроченкова Е.Н, Нагаев И.М, Тархова Н.С, Шепелев В.Н). УБ, 2006. номноос дам эшлэв].

¹² Пунцагноров Ц. Монголын автономит үеийн түүх. УБ, 1955. т. 34.

¹³ Жамсран Л. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. УБ, 1992. т. 22.

¹⁴ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ, 1972. т. 60.

¹⁵ Жамсран Л. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ, 1997. т. 23.

¹⁶ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ, 1972. т. 46.

тэмдэглэсэн байдаг. Энэ ёсоор Их Хүрээний Лавдовский консулаар уламжлуулан Санкт-Петербургт 1911 оны XI сарын 9-нд, монголчууд зэвсэглэн босохоор шийдсэн тул 15 мянган винтов, сумтай мөн төдий тооны сэлэмний хамтаар олгохыг Жибзундамба хутагт хүсчээ¹⁷.

Чингэсний хойно л Эрхүүгийн цэргийн тойргийн штабын генерал Петербургийн цэргийн журганаас тушаал ирсэн ёсоор халх дөрвөн аймагт нэгэн түмэн таван мянган буу гаргаж өгөхөөр тогтож, Хүрээнд цахилгаан мэдээ явууллаа гэж Хайсангаас Котвичэд 1911 оны XI сарын 20-нд илгээсэн захидалд тэмдэглэсэн байдаг¹⁸. Монголын нөлөө бүхий эрх баригчаас зэвсэг хүссэний хойно хэдэн өдрийн дараа Цэргийн яамны сайдынхаа тушаасан ёсоор монголчуудад 15 мянган бердан 7.5 сая сумыг 12 мянган шашка сэлэмтэй өгөхөөр болжээ¹⁹.

Эрхүүгийн цэргийн тойргийн зэвсгийн сангаас Хиагтын хилийн байцаагч хурандаа Хитровоор дамжуулан 1911 сарын XI сарын 5-нд илгээсэн эхний 2.050 бердан²⁰ Монголд хэзээ ирсэн нь тодорхойгүй байна. Гэхдээ доктор Н.Хишигт "Халхад Манжийн төрийг түлхэн унагахдаа монголчууд, Оросын зэвсгийг хэрэглэсэн анхны үр дүнгийн тухай Өргөө дэх Оросын консулаас 1911 оны XI сарын 18-нд өөрийн ГЯЯ-даа илгээсэн мэдээнд"²¹ дурдагддаг тухай өгүүлжээ.

Харин бидний тооцоолсоноор эхний энэхүү хоёр мянган берданыг Эрхүү хотоос Нийслэл Хүрээнд хүргэхэд зам зуур ачиж буулгахыг эс тооцвол тээвэрлэхэд, богино хугацаанд гэвэл 15 хоног, харин удаан бол 18-20 хоног шаардагдах-ёстой. Гэхдээ уг зэвсэг Хиагтад хоёр хоног байсныг тооцвол²² оросоос ирсэн зэвсэг Их Хүрээнд 1911 оны XI сарын 22-ноос 27-ны хооронд ирсэн болж байна.

Хиагтаас гадна мөн Оросын Акша суурингаар дамжуулан монголд зэвсэг илгээж эхэлсэн ба эхний 1.000 берданыг Амурын цэргийн тойргоос 1911 оны XI

¹⁷ Белов Е.А. Россия и Монголия (1911-1919 гг.). М., 1999. с. 47.

¹⁸ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972. т. 73. Оросын армийн хурандаа, инженер А.П.Горлов, ахмад К.И.Гуниус болон Америкийн армийн генерал Hiram Berdan нарын 1868 онд зохиосон 10.66 мм-ийн калибрийн, хүхээртээ нэг сум агуулдаг, замаг нь тууш гулсагч шөвгөн цохилууран ажиллагааны зарчимтай винтов. Тула, Ижевск, Сестроричкийн зэвсгийн үйлдвэрт 3.0 сая ширхэгийг үйлдвэрлэсэн юм [<http://www.ankkurinvarsi.net/jaeger/RIFLES5.htm>].

Шашка-сэлэмний нэг төрөл (Кавказын кабардин-черкес үндэстний урт хутга гэсэн утгатай са'шхо гэсэн үгнээс гаралтай). Оросын армийн хүйтэн зэвсэг. Монголд шашка сэлэмний драгуны загвар орж ирсэн.

¹⁹ Белов Е.А. Россия и Монголия (1911-1919 гг.). М., 1999. с. 47; Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 39.

²⁰ РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7904. л. 194 об. Эх. [Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И, Ганжуров В.Ц, Дмитроченкова Е.Н, Нагаев И.М, Тархова Н.С, Шелелев В.Н). УБ., 2006. номноос дам эшлэв]

1911.12.01 байж болох юм.

²¹ Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 39.

Дээд-Удаас Хиагт хүртэл 200 мод газар, харин Хиагтаас Их Хүрээ хүртэл 350 мод газар зайтай. И. Майскийн баталж байгаагаар монголчууд 11 дүгээр сараас дараа оны 5 дугаар сар хүртэл ихэвчлэн тэмээн хөсөг ашиглах бөгөөд 12 пуд /192 кг/ ачаатайгаар өвлийн цагт өдөрт 30-35 бээр /32-37 км/ газрыг хороодог байна [Майский И. Орчин үеийн Монгол. Автономит Монгол XX зууны гараан дээр. УБ., 2001. т. 187]. Харин дээд тал нь 22 пуд буюу 360 кг ачаатай 3 ба түүнээс дээш морь хөллөсөн тэрэг хоногт 40-43 км замыг туулдаг байна. [Дальний Восток. 1913. №35. с. 12]. Дээрх тооцоог эдгээр баримтад тулгуурлан хийсэн бөлгөө.

²² Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 119.

сарын 5-нд илгээжээ²³. Ийнхүү зэвсгийг “бага багаар, дийлэнхийг нь Манжийн хяналт сул газраар, гэхдээ хувийн журмаар орос иргэдээс монголчууд худалдан авч байгаа”²⁴ хэлбэрээр зөөж эхэлжээ. Эл хэрэгт монголчууд баян ядуу гэлгүй хүчин зүтгэж байлаа. Тухайлбал, Түшээт хан аймгийн Говь түшээ гүний хошууны ард Бөөгийн Шагдар гэгч баян “Орос Улсаас авсан бердан буу гурван мянгыг, олон сумны хамтаар Нийслэл Хүрээнд сэм оруулах ажилд идэвхийлэн оролцож, хувиасаа 200 гаруй атан тэмээ гаргахын хамт, мөн нутгийн олон түмнээс тэмээ, шар үхэр ятган гаргуулжээ”²⁵. Зэвсгийг ийн зөөхөд мөн Оросын ерөнхий консул В.Ф.Люба зэргийн хүмүүс ч биечлэн оролцсож байв²⁶.

Буудлагын зэвсгийн хоёрдахь, гуравдахь хэсэг, 3.552 болон 2.500 берданыг Амурын цэргийн тойргийн зэвсгийн сангаас 1911 оны XI сарын 26-нд хийгээд 1911 сарын 12, 17-нд гаргуулан Хиагтад хүргүүлжээ. Монголчууд буу зэвсэг Хиагтад ирсэн хойно тосон авч зарим хэсгийг шууд хэрэгцээт газруудад хуваарилах ажлыг зохион байгуулж байв. Тухайлбал, туслагч Чойжиннэрэн, түшмэл Цэдэнбалжир нарыг 1911 оны XII сарын 18-нд Хиагт руу илгээн “Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн түшмэд цэргүүдэд түгээн олгуулах (зорилгоор-Б.Б) тус бүр таван зуугаад хонгиот хорголжтой нэжгээд мянган бууг Хиагтын комиссар, майорын газраас хүлээн авч. . . энэ он арван хоёр сарын арванд (1912.01.29) Эрээн цалам”²⁷ харуулаар дамжуулан баруун хоёр аймагт илгээх болов. Үндсэндээ Орос Улс, нийтдээ 9.102 бууг 1911-1912 оны зааг гэхэд Монгол руу илгээсэн байна. Гэтэл Монгол Улсын Дотоод яамны сайд болсон Цэрэнчимэд да ламаас В.Котвичад илгээсэн захидалд 1912 оны II сарын 5-ний үе гэхэд монголд “гаргаж өгсөн буунаас уван цуван энэ хир дөрвөн мянгыг хүлээн”²⁸ авсаныг тэмдэглэсэн байдаг.

1912 оны II сарын 7-ны үед Хиагт болон Акша боомтод сүүлчийн 4.633 берданыг хүргүүлсэнээр Оросын тал нийтдээ 13.735 бууг Монголд шилжүүлэх ажиллагааг дуусгажээ²⁹. Өөрөөр хэлбэл 1912.02/03 сар гэхэд 15.000 ширхэг хүн нэг бүрийн буудлагын зэвсгийг тусламж болгон монголчуудад өгсөн юм.

Гэхдээ Монгол Улсын есдүгээр оны арван сарын хорин зургаанаар өдөрлөсөн (1919.12.17) зэвсгийг ялгаж салгаж бичсэн дансаар бол тэргүүн оны (1911 оны) өвөл цагаас Орос Улсаас авсан бердан буу 11.800, сум 5.310.256 ширхэг³⁰ болж байна. Түүнчлэн сайд Ханддорж нараас 1913.01.28-ний өдөр Оросын ГЯЯ-нд илгээсэн нэгдэх бичигт “эрхэм улс манай Монгол Улсад буу зэвсэг

²³ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 119; РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7904. л. 194 об. Эх.

²⁴ Белов Е.А. Россия и Монголия (1911-1919 гг.). М., 1999. с. 47.

²⁵ Идшинноров С. Улаанбаатар хотын хураангуй түүх. УБ., 1994. т. 58.

²⁶ Бурдуков А.В. В старой и новой Монголии. Воспоминания и письма. М., 1969. сс. 383-384; Гангааням С. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь (1911-1921). УБ., 1993. т. 8.

²⁷ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 122; РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7904. л. 194 об. Эх. [Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц., Дмитроченкова Е.Н., Нагаев И.М., Тархова Н.С., Шепелев В.Н). УБ., 2006. номноос дам эшлэв]

²⁸ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972. т. 127. Монголд өгөх ёстой зэвсгээс 1.265 берданыг, Оросын тал, Хөлүнбуйрт өрнөсөн зэвсэгт тэмцлээс шалтгаалж шууд түүгээрээ барга нарт, 1912.01-02 сард олгожээ.

²⁹ РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7904. л. 194 об. Эх. [Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц., Дмитроченкова Е.Н., Нагаев И.М., Тархова Н.С., Шепелев В.Н). УБ., 2006. номноос дам эшлэв]

³⁰ УТА. Ф. А-5. т. 1. хн. 56.

удаа дараа туслан өгсөн боловч хэрэглэхэд хараахан үл хүрэлцэх³¹ гээд мөн "урьдын үнэлэн өгөхөөр нэгэнт зөвшөөрсөн буу зэвсгээс дутагдан бүхүйг. . гүйцэтгэн гаргуулж өгсүгэй"³² хэмээснээс үзэхүл монголд 15 мянган бердан буу ирсэн гэх асуудал нь эргэлзээтэй байж болох юм.

Монголд ийнхүү зэвсэг олгосон нь Оросын гадаад улс төрийн бодлоготой холбогдох ч 1907 оноос эхэлсэн Оросын армийн цэргийн шинэчлэлтийн үр дүн байж болох талтай. Нэг цэнэглэдэг 4.2 линейний берданыг 1891 онд С.И. Мосиний зохиосон 3 линейний (7.62 мм) хүхээгтээ таван сум агуулдаг винтовоор XIX зууны эцсээс сольж эхэлсэн бөгөөд 1907 оны цэргийн шинэчлэлтээр бердан зэвсэглэлээс хасагджээ. Тиймээс Орос Улс, Манжийн төрийг түлхэн унагахаар зориглосон монголчуудыг зарчмын хувьд хуучирсан ч ашиглах боломжтой берданаар зэвсэглэсэн нь тохиолдлын бус хэрэг. Ер нь 11.8 мянган нэгж буудлагын зэвсэг нь оросын армийн тэр үеийн нэг дивизийн тал хувийг л хангах хэмжээний бөлгөө.

Монголчууд дахин их хэмжээний зэвсгийг, 1912 оны сүүлээр хүлээн авчээ. Тухайлбал, бердан бууны 3.017.500 сумыг 1912.11.15-нд, Мосины загварын 6.000 винтов болон 2 пулемётыг 1912.11.20-нд, 2.000 шашка загварын сэлмийг 1912.11.24, 2 их бууг хормогчын хамт түүний байлдааны иж бүрдэлийг 1912.12.04 ба 28 нд Хиагт руу илгээсэн байна³³. Үүнийг гэрчлэх өөр сурвалжийн мэдээ ч бас бий. Хаант Орос улсад 1913 оны эхээр айлчилсан Монголын төлөөлөгчдийн нэгний тэмдэглэлийн дэвтэрт "дээр олгосон 6.000 винтовоос гадна болж өгвөл"³⁴ дахин 1913 онд буу нэмж авахыг хүссэн тухай тэмдэглэсэн байдаг бол Монголд 1911.11-1912.07 сарын хооронд байсан норвеги гаралтай, ДИУ дахь англи, америкийн тамхины пүүсийн төлөөлөгч Т.А.Рустада, Бээжинд суугч сэтгүүлч Моррисонд хаягласан захидалдаа "Орос Улс Богд гэгээний засгийн газарт 5.000 буу зарсан"³⁵ гэж мэдээлжээ. Сонирхолтой нь Орос Японы 1912.07.08-ний гэрээ байгуулагдахаас өмнө буу зэвсэг нийлүүлэх яриа хэлэлцээг монгол оросын хоёр тал хийсэн бололтой. Ийнхүү шинэ системийн орчин үеийн зэвсэг ирсэнийг монголчууд ашиглаж эхэлсэн тухай нэгэн дуртгалд өгүүлснийг мөн толилуулъя.

Түшээт хан, Сэцэн хан "... аймгийн татагдан ирсэн цэргээс 20-25 насны залуу сэргэлэн хүмүүсийг шилж 200 орчмыг аван, хоёр анги болгож, хуучин шунхуй цэргийн нэмэгдүүлэн барьсан «зүүн хуаран» хэмээх эзэнгүй байранд оруулж ... урт бирдаан буугаар зэвсэглэн тодорхой оноосон монгол даргагүй түр байж байтал орос дарга сурагчид 20 шахам хүн ирж хуарангийн баруун байранд байрлан. . . бас орос винтов, сэлэм талбин олгож урт бирдаан буу хоцрогдов"³⁶ гэж

³¹ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ, 1982. т. 183.

³² Дэндэв Л. XX зууны Монголын түүхийн эх сурвалж. Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд (1911-1921). УБ, 2003. т. 242; В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ, 1972. т. 154.

* Орос, английн хэмжих нэгжийн нэр. Оросынх 2.54 мм-тэй тэнцэнэ.

³³ РГВИА. Ф.2000. Оп. 1. д. 7773. л. 15. Эх. [Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц., Дмитроченкова Е.Н., Нагаев И.М., Тархова Н.С., Шепелев В.Н). УБ, 2006. номноос дам эшлэв]

³⁴ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ, 1972. т. 154.

³⁵ Удо Баркманн. Монголын түүх судлахад зарим хувь хүний архив сонин баримт болдогийн нэгэн жишээ // Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудалд. УБ, 2002. т. 89.

* Урьд 1911 оны сүүл 1912 оны эхээр зүүн хоёр аймгаас татагдан ирсэн 2.370 орчим цэргээс сонгогдсон залуус ажээ.

³⁶ Дамдин Ж. Морьт цэргийн явсан зам. УБ, 1979. т. 45-46.

тэмдэглэсэн байдаг. Монголд шинээр винтов ирсэн төдийгүй түүгээр анхлан Хужиртбулангийн зуутууд зэвсэглэж байсныг дээрх мэдээлэл шууд гэрчилж байна.

Тэр бүү хэл тэдгээр монгол цэргүүд анхлан зэвсэглэсэн бердан буугаа хоцрогдсоныг шууд хэлжээ. Үүнийг давхар гэрчлэх баримт бий.

Урьд нь дөчөөс хорь гаруй жил ашиглагдсан бердан буу шаардлага хангахгүйгээс, Монголын ЦХБЗШЯ-ны сайд, 1912.04 сард ирсэн арван сургагчын тэргүүн А.Ф.Васильевд³⁷ сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн нь, 1912.03.24-өөр өдөрлөсөн, Монголын Сангийн хамаг хэргийг Бүгд захиран шийтгэгч яамны зөвлөх, «Орос-ДИУ-ын банк»-ны Нийслэл Хүрээний салбарын захирал Ф.Москвитинээс, В.Котвичэд илгээсэн захидалд тэмдэглэгджээ.

Тус захидалд "Цэргийн яамны сайд, жишээлбэл есаул Васильевт, оросууд тэднийг шинэ загварын буугаар бус харин хуучирсан берданаар зэвсэглэсэнд дургүйцэж байгаагаа илэрхийлээд, түүнийг сольж болох эсэхийг"³⁸ сурагласан байна. Түүнчлэн Монголын зэвсгийг хураасан, түшмэл Цуй Лужангийн 1919.12.21-ний өдрийн илтгэх хуудсанд³⁹, 1912 оноос эхлэн Орос Улсаас винтов хүлээн авсан гэж дурдсан байдаг.

Нийслэл Хүрээнээ суусан оросын төлөөлөгчдөд, монголчууд 1913 оны хоёрдугаар хагаст 3 линейний шинэчилсэн загварын винтовоос олгохыг хүссэнд, Монголд өнөөг хүртэл эзэмшихэд хялбар энгийн зарчмын зэвсэг хангалттай илгээсэн, сайжруулсан загварын бууг монголчууд эзэмшиж чадахгүй гэж хариулжээ⁴⁰.

Оросоос авсан зэвсэг дотор Хужиртбулангийн цэргийн сургуулийн буу зэвсэг багтдаг. Монгол дахь орос сургагчдын захирагч хурандаа Д.Н.Надежный 1913.05.08-нд цэргийн сургуульд хэрэглэх зэр зэвсгийн жагсаалтыг цахилгаан мэдээгээр илгээсэн байдаг. Үүнд:

Их үхэр буу 2, нэг бүрийн үнэ 9.100 рубль, бүгд 18.200 рубль.

Пулемёт 4, нэг бүрийн үнэ 3.610 рубль бүгд 14.440 рубль, бусад хэрэглэлийн хамт 19.500 руб.

Морин цэргийн буу 1.200, нэг бүрийн үнэ 22 руб. бүгд 26.400 руб.

Морин цэргийн сэлэм 1.300, нэг бүрийн үнэ 8 руб. бүгд 10.400 руб.

Нийтдээ энэ удаад цэргийн сургуульд зориулан 105.620 рублийн зэвсгийг авахыг хүссэн ажээ⁴¹. Харин энэхүү зэвсэг 1913.09 сар гэхэд олгогдоогүй ба энэ үед Санкт-Петербург болон Чит хотоос Эрхүү рүү тээвэрлэгдэж байлаа⁴².

Ер нь Хаант Орос улсаас Монголд 3 удаа зэвсэг нийлүүлсэн⁴³ гэж судлаачид үздэг ба сүүлчийнх нь 1914.09.30-ний гэрээгээр олгогджээ⁴⁴. Монголчууд хүссэн тоогоор оросоос зэвсэг авч чадахгүй байснаас, бусдаас ялангуяа германы чанар сайн зэвсгийг илээр худалдан авч эхэлсэнд Орос Улс дургүйцэн, Хиагтын хэлэлцээрийн үеэр, нууцаар, зэвсэг худалдах гэрээний төсөл

³⁷ Дальний Восток. 1913. №3. с. 3; Белов Е.А. Россия и Монголия (1911-1919 гг.). М., 1999. с. 59.

³⁸ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972. т. 175; Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 39

³⁹ Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. УБ., 1994. т. 161.

⁴⁰ Дальний Восток. 1913. №38. с. 2-3.

⁴¹ УТА. Ф. А-5. д.1. хн.125. т. 1.

⁴² РГВИА. Ф. 2000. оп. 1. д. 4052. л. 60. [Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц., Дмитроченкова Е.Н., Нагаев И.М., Тархова Н.С., Шепелев В.Н). УБ., 2006. номноос дам эшлэв]

⁴³ Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 41.

⁴⁴ Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. УБ., 1994. т. 70-74.

боловсруулан монголчуудад өгсөн нь 1914.09.30-ний гэрээний эх болжээ. Нөгөө талаар дэлхийн дайн эхэлсэн нь бас нөлөөлсөн биз. Дурдсан зүйлсийг харгалзсан гэж үзэж болох гэрээний «Буу сум худалдан авах гэрээ бичгээр» "... үхэр буу зургаа, мөн бууны сум гурван мянга, пулемёт буу дөрөв, мөн бууны дөчин түм, винтов буу хоёр түм, мөн бууны сум хорин саяыг ... (аль) болохоор даруй"⁴⁵ авахаар болсон юм. Гэвч мөнөөх дансаар 1912 оноос эхлэн хүлээн авсан, сургуулийн оросоос удаа дараа хураасан нийлээд 10.274 гурван шугамт винтов болж байгаа нь гэрээг байгуулснаас хойш монголчууд нэмж гэрээнд тусгасан буудлагын зэвсгийн хорин таван хувийг худалдан авсныг гэрчилж байна. Өөрөөр хэлбэл 1912-13 онд 9.310 винтовыг авсан тул 1914 оны гэрээгээр 20.000 винтов бус харин 964 винтовыг монголчууд хүлээн авсан бололтой. Буу зэвсэг гэрээний тоонд хүрээгүй нь 1914.07.28/08.01-ний үед эхэлсэн дэлхийн дайнтай холбогдох ч, бас Монголын талын төлбөрийн чадвараас шалтгаалсан байж болох юм.

Монгол Улсын шинэ үеийн үндэсний зэвсэгт хүчний хөгжлийн эхэн шат болох 1911-1921 онд монгол цэргийн зэвсэглэлд артиллер, пулемётын эзлэх жин бага хувийг эзэлж байсан ч энэ төрлийн зэвсэг ямагт Монголын эрх баригчдын анхаарлын төвд байсаар иржээ. Учир нь тухайн үеийнхээ технологийн ололт дэвшилтийг ашиглан бүтээгдсэн их буу, пулемёт нь хөнөөлийн боломж, адаглаад сүрдүүлэх чанар нь ашигтай агаад давших, хориглох байлдаанд чухал үүрэгтэй юм.

Тусгаар улсаа сэргээснээс хойш монгол цэрэг артиллерийн зэвсгийг хэрэглэсэн анхны байлдаан бол Ховд хотыг чөлөөлөх тулалдаан билээ. Гэвч энэ тулалдаанд монголчууд бүр XVII-XVIII зууны пицалийг хэрэглэжээ⁴⁶.

Харин орчин үеийн пулемёт, артиллертай, монголчууд анх 1912.11/12 сард танилцжээ. Монгол Улсаас 1913.02-1914.09 сарын хооронд олон удаагийн гэрээ, наймаагаар уулын, хээрийн төрлийн их, дунд, бага калибрийн 114 их буу, 157 пулемёт худалдан авах оролджээ. Гэтэл 1919 оны дансаар худалдан авсан пулемёт 7, олзлон хураасан 6, бүгд 13 пулемёттой, янз бүрийн калибрийн их буу 10, олзлон хураасан бага үхэр буу, гунан буу 3 нийт 13 артиллертэй байжээ⁴⁷. Өөрөөр хэлбэл худалдан авахаар тохирсон Шифлерь ба Мүгдэний герман пүүст захиалсан 23, гэрээгээр Оросоос худалдан авах их бууны дийлэнхийг аваагүйтэй хөлбоотой. Монголд 1912.12.04/ 28-нд анх 2 их буу ирсэн бөгөөд 1913.2/3 сар болон есөн сард 12 их буу иржээ. Харин дансаар 10 их буу байгаа юм.

1912.11 сард моринд ачдаг, гурван хөлтэй пулемёт хоёр иржээ. Үүний дараа 1913.09 сард Хужиртбулангийн цэргийн сургуулийн сургалтад зориулан 4 пулемёт худалдаж авсан ба харин дансаар бол нэг пулемётыг хэзээ худалдаж авсан тодорхойгүй байгаа юм.

Морин цэргийн гол зэвсгийн нэг сэлмийг, Хаант Орос Улс монголчуудад өгөхөөр шийдсэнийг дээр өгүүлсэн. Гэвч Оросын ЦЯЯ-ны сайдын тушаалд заасан тоогоор олгогдоогүй ба 1912.11 сард 2.0 мянгыг харин 1913 онд 1.300-г худалджээ. Үүнээс өөр хүйтэн зэвсэг их хэмжээгээр худалдан авсан баримт одоогоор алга. Харин 1919 оны данс тооллогоор 9.608 ширхэг сэлэм, бусад төрөл загварын 608 сэлмийг хураасан байдаг.

Хаант Орос Улсаас илгээсэн зэвсгийг дараахь хүснэгээр үзүүлье.

Хүснэг 1

Нэр	Хүсэлт гаргасан тал	Огноо	Тоо	Сум/т./	Илгээсэн дүн
-----	------------------------	-------	-----	---------	--------------

⁴⁵ Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. УБ., 1994. т. 72.

⁴⁶ Соркин Н.С. В начале пути. М., 1970. с. 108.

⁴⁷ УТА. Ф. А-5. т.1. хн.56. т. 26-28.

Бердан.	Монгол Улсын Засгийн газар. 1911.08/11 сар 15.000 ширхэг буу 7.5 сая ширхэг сум	1911.11.05	3.050		13.735 бердан 5.310.256 сум
		1911.11.26	3.552		
		1911.12.17	2.500		
		1912.02.07	4.633		
		1911-1912		2 292.756	
		1912.11.15		3.017.500	
Винтов.	МУ-н ЗГ. Ханд ван нарын. ОУ-н Е. К-н. Е. Кн. 10 мян вин. 5 сая сум Хурандаа Д.Н.Надежный-н.	1912.11.20	6.000		8.110 винтов
		1913.03	10		
		1913.06	100	50.000	
		1913.09.10	2.000	1.500.000	
		1913.09.04	1.200	498.000	1.2/498.0 м.
Пулемёт	МУ-н ЗГ. Хурандаа Д.Н.Надежный-н.	1911.11.20	2		6 пулемёт 72.000 сум
		1913.09.04	4	72.000	
Их буу	МУ-н ЗГ. Д.с.с. И.Я.Коростовец ийн. Хурандаа Д.Н.Надежный-н.	1912.12.04/28	2	Галт хэр.	14 их буу 12.000 сум
		1913.02	4	4.000	
		1913.09.24	4	4.000	
		1913.03.0	4	4.000	
Сэлэм	МУ. ЗГ. 1911 он, 12 мян сэл. Хурандаа Д.Н.Надежный-н.	1912.11.24	2.000		9.608 сэлэм
		1913.09.04	1.300		

Орос Улсаас 3 удаа зэвсэг авсаны адил мөн 3 удаа зэвсэг худалдан олгохыг хүсээд бүтээгүй тохиолдол бий. 1913 оны I сарын 17-нд Орост айлчилсан Монголын төлөөлөгчдийн тэргүүн Ханддоржийн тэмдэглэлийн дэвтэрт, 1913 оны I сарын 5-ний өдрөөр тэмдэглэгдсэн, магадгүй Монголын Засгийн газарт боловсруулсан байж болох төслөөр "10 хүртэлх дунд калибрийн пушка, түүний сум 5 мянга, пулемёт 6 (сум 2 түм), байлдааны 20 мянган винтов, тус бүрийн 2 мянган сумтай. Дараа нь цэргийн жургаанаас эвдрэлтэй хэмээн тооцсон нь чухам бидний хувьд сургалтад шаардлагатай, хэрэгцээг хангахуйц, одоо Эрхүүд байгаа 8 пушкийг"⁴⁸ худалдан авахаар төлөвлөжээ. Гэтэл төлөөлөгчдөд 1913 оны I сарын 26-нд ирсэн цахилгаан мэдээнд Монголын "өмнөд хязгаарын газарт хятадын цэрэг үлэмжхэнээр халдаар"⁴⁹ ирсэн бөгөөд дайтах байлдах нь гарцаагүй болсныг мэдээлээд худалдан олгуулах зэвсгийн тоог шинээр тогтоосон байна. Энэ ёсоор урьд худалдахаар амласан 5 их буу, 10 пулемётын оронд⁵⁰ 32 их буу, 64 пулемёт, хэд хэдэн түмэн винтов худалдан олгохыг хүсэж, 1913 оны I сарын 28-нд Оросын ГЯЯ-нд албан бичиг илгээжээ. Хариу нь 1913 оны II сарын 3-нд ирсэн ч тодорхой шийдийг агуулаагүй байв. Дахин 1913 оны III сарын 5-нд "үхэр буу гуч, пулемёт буу

⁴⁸ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972. т. 272.

⁴⁹ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 183.

⁵⁰ Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 39.

жар, винтов буу арван түмийг. . . одоо даруйхан гаргуулж⁵¹ туслахыг хүссэн албан бичиг илгээсэн ч мөн адил хариуг авсан аж. Мөн оны сүүлээр Орост айлчилсан ерөнхий сайд Намнансүрэн 1913 оны XII сарын 17-ноос Оросын ГЯЯ-нд илгээсэн бичигтээ “бага хэмжээний сайн үхэр буу зургаа, сум гурван мянга, пулемёт дөрөв, сум дөчин түм, винтов хоёр түм, сум хорин саяыг. . . олгож өгөхийг хүсэхээс гадна үнэ мөнгөнөөс хагас хувийг бэлхэнээ тушаан өгөх⁵² тухай мэдэгджээ. Гэвч оросууд цааргалсаар 1914 оны IX сарыг хүргэжээ.

Удаа дараа татгалзсан хариу аваад монголчууд албан бус шугамаар зэвсэг худалдаж авахыг оролдож эхэлжээ. Тухайлбал, 1913 оны III сарын 5-нд “үхэр буу гуч, пулемёт буу жар, винтов буу арван түмийг. . . одоо даруйхан гаргуулан⁵³ туслахыг хүссэн албан бичигт татгалзсан хариу авсаны дараа Санкт-Петербургийн зэвсгийн үйлдвэрийн ерөнхий захирал, Герман, Дани, Бельгийн зэвсгийг орост худалдаалах онцгой эрхийг эзэмшигч Феодор Карлович Шифлерьтэй яриа хэлэлцээр эхэлжээ. Улмаар тодорхой тооны зэвсэглэлийг дараах нөхцөлтэйгээр авахаар болсныг Засгийн газартаа мэдээлсэн байна. Тус бичигт: “. . . манай сайдуудыг Орос улсын нийслэл хотноо бүхий дор энэ жил хаврын тэргүүн сарын 29 (1913.03.06)-нд, Дани улс, Бельги улсын сангийн буу зэвсгийг дамжуулан худалдах пүүсний тэргүүлэгч Оросын худалдаачин Шифлерь хэмээгч Феодор харилцаж, манай Монгол Улсын Нийслэл Хүрээний зэрэг газар зүйл бүрийн буу зэвсэг сум ба цэргийн хэрэгсэл худалдах пүүс нээж болмуй хэмээн гуйн ирсэн тухайд манай Засгийн газар үхэр буу, пулемёт, винтовийн зэрэг буу сумыг хэрэглэх тухай бүр ирсэн тооны ёсоор данс авчирч өгөхөөр хэлэлцэн. . . ”⁵⁴ тогтож холбогдох үнэмлэх бичгийг олгожээ. Өөрөөр хэлбэл, монголд зэвсгийн пүүс, дэлгүүр нээх хүсэлтийг нь, 6 сарын дотор 8 хээрийн их буу, пулемёт, 5 мянган винтовыг их бууны 500, пулемётын 50.000, винтовын 1.000.000 сум хэрэгсэлтэй захиалсаны хариу болгон зөвшөөрчээ⁵⁵.

Захиалсан зэвсгийн эхний хэсэг 1913 оны III сарын 17-ноос V сарын 10-ны хооронд Монголд ирсэн ба үнийг төлсөн тухай Петербургт сууж байсан ДИУ-ын элчин Лю Цзюньжэнь Бээжинд мэдээлсэн байдаг⁵⁶. Түүнчлэн монголд нийлүүлэх ёстой «Гочкис» системийн 45 мм-ийн уулын их буу, тус бүр нь 28 сумтай 16 хайрцагны хамтаар, Геве, Маузер системийн 1888, 1898, 1905 оны загварын винтов, карабиныг гаалийн татвараас чөлөөлүүлэхээр Ф.К.Шифлерь 1913 оны X сарын 7-нд Нийслэл Хүрээнд бичиг илгээсэн мэдээ бий⁵⁷.

Гэвч эдгээр зэр зэвсэг монголд орж ирсэн нь эргэлзээтэй. Учир нь Ф.К.Шифлерийн монголд нийлүүлэхээр Олноо өргөгдсөний 3-р оны зуны сүүл сард (1913.07.05-08.02) бэлтгэсэн 4 их буу, түүний 500 сум, 50.000 сумтай 4 пулемёт болон байлдааны иждээ тус бүр 2.000 сумтай таван мянган винтовыг Оросын тал өөрийн хил дээр саатуулсан тул түүнийг гаалийн татваргүй хил давуулан, монголд нэвтрүүлэх зөвшөөрөл хүсэж, 1913 оны VIII сарын 22-нд Нийслэл Хүрээнд суугаа Оросын консулын газар бичиг илгээн мэдэгдэж байжээ⁵⁸.

⁵¹ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 182-184, 191.

⁵² Дэндэв Л. XX зууны Монголын түүхийн эх сурвалж. Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд (1911-1921). УБ., 2003. 242.

⁵³ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982. т. 191.

⁵⁴ УТА. Ф. А-3. д. 1. хн. 435. н. 1.

⁵⁵ УТА. Ф. А-3. д. 1. хн. 493. т. 54; Дальний Восток. 1913. №17. с. 5; Энхжин С. Монголын төр, үндэсний сэргэн мандалт. УБ., 1999. т. 66.

⁵⁶ Дальний Восток. 1913. №17. с. 5.

⁵⁷ Энхжин С. Монголын төр, үндэсний сэргэн мандалт. УБ., 1999. т. 66.

⁵⁸ УТА. Ф. А-3. д. 1. хн. 493. т. 54.

Монгол Улс оросоос өөр газраас зэвсэг авах оролдлогыг цөөнгүй үйлдэж байсныг өмнө өгүүлсэн. Ялангуяа Өмнөд Монголын төлөөнөө ДИУ-ын цэрэгтэй 1913 оны турш дайтахад буу зэвсэг, пулемёт, артиллер ихээр шаардагдах болсон. Тиймээс бүх сувгаар, бололцоо, эдийн засгийн чадавхидаа тулгуурлан зэвсэг худалдан авахыг эрмэлзсэн ажээ. Японы «Мансю ници ници» сонины 1925-р дугаарт нийтэлснээр монголчууд Мүгдэний герман худалдаачнаас 1913 оны II сарын 19-ний үед "9 мянган винтов, 14 хурдан буудагч их буу, 10 сая галт хэрэгсэл худалдан авч байна"⁵⁹ гэж байдаг. Түүнчлэн мөнөөх Рустада, 1912 оны III-VI сард "Манжуурын зэвсгийн наймаачин нэг герман хүн ирж, монголчуудад 1000 буу зарлаа. Оросын консул Люба энэ наймааг зуучилсан учир тэр герман наймаачнаас (энэ нь дээрх Мүгдэний наймаачин байж болох талтай-Б.Б) шан харамж"⁶⁰ авсан гэж мэдээлж байв. Гэхдээ их хэмжээгээр зэвсэг авсан тухай өөр баримтгүй тул эл мэдээлэл үндэслэлгүй байж⁶¹ болох ч цөөн тоогоор герман зэвсэг авсан байх болов уу. Учир нь Орос дахь ДИУ-ын элчин Лю Цзюньжэнь Монголын Засгийн газар оросоос нууж германд зэвсэг захиалсан ба заримынх нь үнийг төлж эхэлснийг олж мэдсэн Оросын Засгийн газар дургүйцлээ илэрхийлэн зээлээ эргүүлж авна гэж сүрдүүлсэн гэж өөрийн Засгийн газартаа мэдэгдсэн юм⁶². Гэвч монголчууд 1913 оны IX сарын үест 1000 винтов, 5 пулемёт, 5 их буу нэмж авахаар болжээ⁶³. Ер нь монголчууд "Харбинаас их хэмжээний буу сум худалдан аваад Манжуураар Монгол руу зөөдөг (бөгөөд), хаана хэнээс зэвсэг авч чухам ямар замаар тээвэрлэдэг тухай тодорхой мэдээлэл цуглуулахын тулд (Мүгдэний) амбан туршуулаа илгээж"⁶⁴ байв. Гэхдээ 1913.09 сард авсан гэх зэвсэг нь Мүгдэний 1913.02.19-ний тохиролцооны үргэлжлэл байж болох юм.

Монголчууд гаднаас буудлагын зэвсэг худалдаж авах гэж оролдсон хийгээд худалдан авсан тохиолдлуудыг дээр өгүүлсэндээ түшиглэн түүвэрлэн жагсаая.

Монголын хүссэнээр, Оросын ЦЯЯ-ны сайд В.А.Сухомлинов, монголчуудад шилжүүлэхээр 15.0 мянган бердан, 7.5 сая сум, 12.0 мянган шашка сэлмийг Эрхүү болон Амурын мөн Амур хавийн цэргийн тойргийн зэвсгийн агуулахаас гаргахыг тойргийн штабуудад тушаав (1911.11.04).

1911.11.05-наас 1912.02.07 хооронд 6 удаагийн тээвэрлэлтээр 13.735 берданыг Монгол руу илгээсэн.

1911.11.05-наас 1912.02.05 гэхэд 4.000 бердан монголд орж ирсэн бөгөөд тус оны хавар гэхэд нийт 11.8 мянган бердан 5.310.250 сумыг Монголын талд нийлүүлж дуусчээ.

1912.03-06 сард Манжуурын герман худалдаачнаас Оросын консул Любагийн зуучлалаар 1000 винтов худалдан авах гэрээ байгуулсан бололтой.

1912.11.20-12.28 ний хооронд Орос Улсаас 6.000 винтов, 2.000 шашка сэлэм, 2 их буу, моринд ачдаг 2 пулемёт, 3.017.500 берданы сумыг Монгол руу илгээжээ.

1913.01.18-нд Монголын Засгийн газар Орос Улсаас урьд амалсан 5 их буу, 10 пулемётын оронд дунд калибрийн 10 хүртэлх пушка 5.0 мянга сумтай, цэргийн сургалтанд зориулан, Эрхүүгийн агуулахад хадгалж байсан эвдэрэлтэй гэх 8 пушка, 6 пулемёт 20.0 мянган сум, тус бүр нь 2.000 сумтай 2.0 түм винтов худалдан авахаар төлөвлөжээ.

⁵⁹ Дальний Восток. 1913. №8. с. 7.

⁶⁰ Удо Баркманн. Монголын түүх судлахад зарим хувь хүний архив сонин баримт болдогийн нэгэн жишээ // Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудалд. УБ., 2002. т. 89.

⁶¹ Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916 гг.). // В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001. с. 39.

⁶² Дальний Восток. 1913. №18. с. 4.

⁶³ Дальний Восток. 1913. №39. с. 2.

⁶⁴ Дальний Восток. 1913. №39. с. 3.

- 1913.01.28-нд Монгол Улс, Оросоос 32 их буу, 64 пулемёт, хэд хэдэн түм винтов худалдаалахыг хүсжээ.
- 1913.02.03-нд Хаант Орос улсын Засгийн газар, Гадаад явдлын яамнаас тун бүрхэг хариу өгөв.
- 1913.02.19-нд Мүгдэний герман пүүсээс 9.0 мянган винтов, 14 их буу, 10.0 сая галт хэрэгсэлийг худалдан авахаар тохиролцов.
- 1913.02 сард И.Я.Коростовецийн зуучлалаар Оросоос 4.000 сумтай аргентиний гэгдэх 4 их бууг хүлээн авчээ.
- 1913.03.03-нд 75 мм-ийн 4.000 сумтай 4 их бууг хүлээлгэн өгчээ.
- 1913.03.05-нд үхэр буу гуч, пулемёт буу жар, винтов буу арван түмийг одоо даруйхан гаргуулж туслахыг хүссэн албан бичиг илгээн Орос Улсаас дахин хүссэн ч мөн адил хариуг авсан аж.
- 1913.03.06-нд Петербургийн Шифлерийн пүүсэнд, монголд зэвсгийн пүүс, дэлгүүр нээх хүсэлтийг нь, 6 сарын дотор 8 хээрийн их буу, пулемёт, 5 мянган винтовыг их бууны 500, пулемётын 50.000, винтовын 1.000.000 сум хэрэгсэлтэй захиалсаны хариу болгон зөвшөөрчээ.
- 1913.05.28-нд Хужиртбулангийн цэргийн сургуулийн хэрэгцээнд зориулан 1.200 винтов, 2 хээрийн их буу, 4 пулемёт нийт үнийн дүнгээр 105.620 рублийн зэвсгийг Орос Улсад захиалав.
- 1913.08.22-нд Нийслэл Хүрээнд суугаа Оросын консулын газар, 1913.07.05-08.02-д, Ф.К.Шифлерийн монголд нийлүүлэхээр бэлтгэсэн 4 их буу, түүний 500 сум, 50.000 сумтай 4 пулемёт болон байлдааны иждээ тус бүр 2.000 сумтай 5.000 винтовыг Оросын тал өөрийн хил дээр саатуулсан тул түүнийг гаалийн татваргүй хил давуулан, монголд нэвтрүүлэх зөвшөөрөл хүсэж, бичиг илгээн мэдэгджээ.
- 1913.09.04-ний үед Хужиртбулангийн Монголын морин бригадын цэргүүдийн хичээл сургалтад зориулан Орос Улсаас байлдааны 432.000 сум, хоосон 60.000 сум болон сургуулилтын зориулалтай 6.000 сум, 2.400 дайз бүхий 1.200 винтов, 1.300 шашка сэлэм хуйтайгаа, 72.000 сумтай моринд ачдаг гурван хөлт пулемёт 4-ийг, 4.000 байлдааны, 40 хоосон, 20 сургалтын сумтай, 4 дуран, өнцөг хэмжигч, Цейсийн хоолой, телофон утас тус бүр нэг, галт байр төхөөрөмжлөх хэрэгсэл их бууны салаа болгонд нэг оногдохоор тооцолж, 75 мм-ийн хээрийн их буу 4-г Эрхүүгээс илгээх болжээ.
- 1913.09.10 гэхэд Дээд Шивээд 1 сая сум бүхий 2.000 винтовыг монгол руу илгээхээр бэлдсэн ба үлдсэн 4 сая сум, 8.0 мянган винтовыг Монголын Засгийн газрын хүсэлтээр, Оросын Жанжин штабын Ерөнхий хэрэг эрхлэх газартай, Эрхүүгийн цэргийн тойргийн Их бууны газраас, монголчууд ямар хэрэгт зарах гэж байгааг харгалзан, тухай бүрт зөвлөөд олгож байхаар тогтжээ.
- 1913.09 сард Герман худалдаачнаас 1.000 винтов, 5 их буу, 5 пулемёт худалдан авахаар тохиролцов.
- 1913.10.27-нд Шифлерь Монголын талд хүлээлгэн өгөхөөр зэхсэн зэвсгийн төрөл зүйлийг жагсаасан баримтыг илгээжээ.
- 1913.12.27-нд монголчууд, 6 их буу 3.000 сум, 4 пулемёт 4 түм сум, 2 түм винтов 20 сая сум худалдан авах төслийг Оросын талд хүлээлгэн өгсөн.
- 1914.09.03-нд Миллер зэвсэг худалдан өгөх гэрээний эхийг Монголд хүлээлгэн өгөв.
- 1914.09.30-нд 1913 онд үйлдсэн төслөөр зэвсэг худалдах гэрээг хоёр тал байгуулжээ.

Энэхүү жагсаалтаас үзвэл, худалдан авах гэж оролдсон (давхардсан тоогоор) **буудлагын зэвсгийн 20,51 %-ийг буюу 22.184 нэгж янз бүрийн калибрийн**

бууг, сум галт хэрэгсэлээс нь 12,69 %-ийг буюу 10.713.356 ширхэг сумыг, их буунаас 8,77 %-ийг буюу 10 нэгжийг, их бууны 38.000 (8.500) сум буюу авах гэж оролдсоны 15,27 (68,25) %-ийг, пулемётоос 4,46 %-ийг буюу 7 нэгжийг, пулемётын сумны 8,3%-ийг харин сэлэмний 80,06 %-ийг буюу 9608 ширхэгийг ямар нэгэн арга замаар Монголын Засгийн газар худалдан авч чадсан байна.

Дайн байлдааны цагт эсрэг талаасаа зэвсэг олзлон өөрийгөө зэвсэглэдэг практик аль ч орны армид байдаг үлгэрээр монголчууд ч гэсэн чингэж зэвсэглэж байв. Тухайлбал 1911.11-1912.08 сарын хугацаанд Их Хүрээ, Улиастай, Ховд хотод байсан болон Алтайн Шар сүмээс ирсэн Манж Чин болон ДИУ-ын цэргээс 500 орчим нэгж буу, 2 түм гаруй сум олзлон хураасан байдаг. Тэгвэл бүрэн бус тооцоогоор 1913 онд зөвхөн Дархан Уул, Хошмог, цахарын Хөвөөт шар хошуу зэрэг таван газарт, ДИУ-ын цэрэгтэй байлдаад 1.084 орчим төрөл бүрийн буу, 2 хасаг тэрэг сум галт хэрэгсэл түүнээс гадна 85.600 сум, 304/411 сумтай 4 их буу, 5.000 сумтай 6 пулемёт олзолсон байдаг. Ерөнхийдөө 1911-1919 оны хооронд болсон дайн байлдаанаас бүрэн бус судалгаагаар винтов, бердан зэрэг 9 төрлийн 1.693 буу, 156.961 орчим сум, 4 их буу түүний 304/411 сум, 5.0 мянга орчим сум бүхий 6 пулемёт олзолжээ. Олзолсон зэвсгээс зөвхөн данслан хураасан нь ийм байх тул дайн байлдаанд хэрэглэж үрсэн нь мэдээж цөөнгүй байх нь ойлгомжтой.

Ер нь Монгол Улс хэдий хэрийн зэвсэгтэй байсныг хүснэглэн үзүүлье.

Хүснэгт 2

Зэвсгийн нэр	Зэвсэглэлд орсон хэлбэр	1911.11 сараас 1919 оны 12 сар			1919.12.21-ний дансаар
		Тоо	Бүгд	Сум	
1. Бамали	Дээрээс хайрласан	58	352 буу		182 буу
	Олзлон хураасан	294	60.095 сум	60.095	22.325 сум
2. Маузер	Худалдан авсан	35		51.005	9 буу, 35.323 сум
3. Браунинг		3		212	
4. Моосу	Хурааж, олзолсон	475		86.115	
5. Сайсанли		140		28.599	
6. Си мии лии		2		3.600	
7. Хавчиг бердан		52	790 буу 169.703 сум		
8. Винчестер		46		172	
9. Их бага шагж		5			
10. Юнь		27			
11. Тяньпай		3			
12. Шувууны		1			
13. Цахиур		1			
14. Бердан	Худалдан авсан	11.800	12.863 буу	5.310.256	2.456 буу
	Олзлон хураасан	1.063	5.312.697 с.	2.441	714.749 сум
15. Винтов	Худалдан авсан	9.200		4.971.100	
	Хужиртбулангийн	1.074	10.365 буу	131.221	5.776 буу
	Дээрээс хайрласан	30	5.433.756 сум	8.310	874.363
	Олзлон хураасан	61		323.125	
Бүгд буудлагын зэвсэг		24.370		10.976.251	9.148 (9.187) буу 1.765.458 (1.690.862) сум
16. Их үхэр буу	Хүлээн авсан	2		814	1 их буу, 525 сум
17. Бага үхэр буу	Хүлээн авсан	8	9 бага их буу.	4.987	5 бага үхэр буу
	Олзлон хураасан	1	5.242 сум	255	4.837 сум
18. Гунан буу	Олзлон хураасан	2		49	2 гунан буу, 49 сум
Бүгд их буу		13		6.105	7 (уг нь 8 байлтай) иб. 5.411 (5.410) сум
19. Пулемёт	Хүлээн авсан	7	13 пулемёт		10 пулемёт, 193 сумтай хайрцаг, 40 дайз
	Олзлон хураасан	6			
Бүгд пулемёт		13			10 пулемёт, 193 сумтай хайрцаг, 40 дайз

Түүнчлэн Монгол Улсын зэвсгийн санд, Орос Улсаас авсан сэлэм 9.608, бүр дундад зууны хуучин бялтат буу 1.435, галт буу 652, нум 2.000, харвуулын сум, хоромсог, саадаг, ширэн хуйтай илд 608 байв. Эдгээр зэвсгээс хаана, хэнд, хэрхэн зарцуулсныг доорх жагсаалтаар үзүүлье. Үүнд:

а/ Винтов буу:

1.1912 он

Зүүн хуучид вангийн хошуу-62
Баруун хуучид вангийн хошуу-20
Улаанцавын чуулган-100
Хөх нуур-4
Хөлүнбуйр-1.000
гүн Бавуужавын цэрэгт-60
Дүн-1.246

2.1913 он

Бэйс Насанравжих, Буянравжих-189
гүн Найданжав, Насантогтох-340
бэйс Чимэдсэрэн-376
Гарьдын цэрэгт-100
тайж Эрдэнийн цэрэгт-19
Ширээт ламын цэрэгт-30
Жарудын гүн Гомбожав, Түмэн-
Өлзий нарт-10
Өлзий-орших, Шарав нарт-50
цахар Ганжууржав-9
Засагт ван Удайн цэрэгт-7
Оннигуд бэйлийн хошуу, тайж
Самбууд-3
Дүн-1.133

3.1916 он

Егүзэр хутагтын газраа ирсэн ДИУ-
ын цэрэгт алдсан-334
Баруун өмнө хязгаарт сэргийлэн
суулгасан Түмэдийн нэг хороо
цэрэгт-187
Ордосын цэрэгт-185
Урадын өмнөд бэйс
Хишигдэлгэрийн хошуу-100
Урадын дундад бэйс Бавуудоржийн
хошуу-30
Урадын хойд бэйс Рашнамжилдорж,
Муу Мянган хошууны засаг ноён
Рашцэрэндорж нарт-20
Хятад цэрэг Жү Линшад-1
Дүн-808

4.1917 он

Дайсанд олзлуулсан-8
Өмнөд монголчуудад, бүгд 3.195
винтов, зохих галт хэрэгслийг өгчээ.

б/ Бердан буу:

1.1912 он

Жиримийн чуулганы ван Удай,
бэйл Бадамравдангийн хошуудад-
2.000
мөн чуулганы ван Амарлингуйн
хошууны бэйс Насанравжих-1.000
Цахар Хөвөөт шарын хошуу-200
Зүүн хуучид вангийн хошуу-62
Баруун хуучид вангийн хошуунд-50
Хөлүнбуйр-2.000
Зуу-Удын Баарин хошуу-200
Хишигтэн хошуу, тайж Долгоржавт -
200
Хөх нуурын ван Лхаваринчин
нарын хошуудад-701
Зуу-Удын Найман, Оннигуд бэйл
нарын хошуудад-40
Улаанцавын чуулган дарга ван
Лхаванноровын газарт-200
Их Зуугийн чуулганы Доной
бэйсийн хошуу-3
мөн чуулганы Отог бэйлийн хошуу-
100
Улаанцавын чуулганы Дархан ван
Ёндонванчигийн хошуу-3

2.1916 он

Егүзэр хутагтын газраа ирсэн ДИУ-
ын цэрэгт алдагдсан-817
Цахарын гүн Донровын харъяат
цэргийн авч оргосон-5
байлдаанд алдагдсан-11
Нийт 7.592 бердан, 3.188.542 сумыг
Өмнөд Монгол руу илгээжээ.

в/ Бамили буу:

1.1912 он

Өмнөд Монголын хошуудад-89

2.1916 он

Дайсанд алдсан-49
Бүгд-138.
Нийт 10.925 буудлагын зэвсгийг
өвөрлөгч нарт илгээсэн байна.

Монгол Улсын шинэ үеийн, үндэсний зэвсэгт хүчний зэр зэвсэг, түүнийг хэрхэн олж авч цэрэг эрсээ зэвсэглэж байсан, юунд зарцуулж байсан талаар өгүүлснээс дараах хэдэн зүйл ойлгогдож байна.

Нэг, тусгаар тогтнолын төлөө хоёр зуун жил тэмцсэн монголчууд зэвсгийг ямагт дээдэлж, бололцооныхоо хэрээр олж бэлтгэдэг байжээ.

Хоёр, буу сумыг худалдан авах, олзлох зэрэг бүх аргаар олж авч байв.

Гурав, 1915 он гэхэд 24.000 цэрэг зэвсэглэх хурдан буу, цөөн тооны их буу, пулемёттой болжээ.

Дөрөв, гадаад улс гүрэн, хувь хүнээс худалдаж авсан буудлагын зэвсгээс Өмнөд монголчуудад төрөл бүрийн 10.925 бууг олгосон нь Өмнөд Монголд халдсан ДИУ-ын цэргийн довтолгоог няцаасан «таван замын» цэрэг дайны ажиллагаанд амжилт олж, улмаар Халх Монголын хил хязгаарыг батлан бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болсныг тэмдэглэвэл зохино.

Abstract: Early XX century an armament of Mongolia was inadequate and low level comparing with the neighbours. The newly established government was working hardly on this issue. The armament is one of the main goals of the government. Especially, artillery weapons, machine guns and rifles are urgently need. The article includes tables and documents about Mongolian army power as showing the results of battles between the army and marauders of China.

Ашигласан материал

1. БНМАУ-ын түүх. Дэд боть (1604-1917). УБ., 1968
2. Батсайхан О. Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ (1911-1916). УБ., 2002
3. Гангааням С. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь (1911-1921). УБ., 1993
4. Дамдин Ж. Морьт цэргийн явсан зам. УБ., 1979. т. 45-46
5. Дэндэв Л. XX зууны Монголын түүхийн эх сурвалж. Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд (1911-1921). УБ., 2003
6. Жамсран Л. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. УБ., 1992
7. Жамсран Л. Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт. УБ., 1997
8. В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг. УБ., 1972
9. Идшинноров С. Улаанбаатар хотын хураангуй түүх. УБ., 1994. т. 58
10. Магсаржав Н. Монгол Улсын шинэ түүх. УБ., 1994
11. Майский И. Орчин үеийн Монгол. Автономит Монгол XX зууны гараан дээр. УБ., 2001
12. Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914). УБ., 1982
13. Монгол-Оросын цэргийн хамтын ажиллагаа (1911-1946). (Баримтын эмхтгэл). I боть. 1911-1936. (Эмхтгэгчид: Т.Оюунбазар, Д.Гомбосүрэн, Н.Хишигт, Ж.Гантулга, Кудрявцев И.И., Ганжуров В.Ц, Дмитроченкова Е.Н, Нагаев И.М, Тархова Н.С, Шепелев В.Н). УБ., 2006
14. Пунцагноров Ц. Монголын автономит үеийн түүх. УБ., 1955
15. Хишигт Н. Монгол улсаас хаант Оростой цэргийн салбарт байгуулсан гэрээ хэлэлцээрүүд (1912-1917) // SH. Tom. 32. УБ., 2002
16. Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны гэрээ (өдөр тутмын тэмдэглэл). УБ., 1999
17. Удо Баркманн. Монголын түүх судлахад зарим хувь хүний архив сонин баримт болдогийн нэгэн жишээ // Монголын үндэсний хувьсгалын түүхийн асуудалд. УБ., 2002
18. УТА. Ф. А-3. д.1. хн.435, 493. н. 1, т. 54; А-5. д.1. хн.56, 125. т. 1, 26-28
19. Энхжин С. Монголын төр, үндэсний сэргэн мандалт. УБ., 1999
20. Белов Е.А. Россия и Монголия (1911-1919 гг.). М., 1999. с. 47
21. Бурдуков А.В. В старой и новой Монголии. Воспоминания и письма. М., 1969.
22. Дальний Восток. 1913. №3, 8, 17, 18, 35, 38, 39, 51
23. Лузянин С.Г. Россия-Монголия-Китай в первой половине XX века. Политические взаимоотношения в 1911-1946 гг. М., 2003
24. Советская историческая энциклопедия. Том. XII. М., 1969
25. Соркин Н.С. В начале пути. М., 1970. с. 108
26. Хишигт Н. Монголо-Российское сотрудничество в военной области (1911-1916гг.). //В сб. Россия и Монголия новый взгляд на историю взаимоотношений в XX веке. М., 2001
27. <http://www.ankkurinvarsi.net/jaeger/RIFLES5.htm>